


Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна



Бурханы
хүчит
эр
Самсон



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Janie Forest; Alastair Paterson

Найруулсан: Lyn Doerksen

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2021 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Эрт урьдын цагт
Израйл нутагт Маноа
гэдэг нэгэн хүн
амьдардаг
байв.**

**Тэр
эхнэр
авсан ч
хүүхэдгүй
байлаа.**



**Нэгэн өдөр Эзний тэнгэр элч
Манаогийн эхнэр дээр хүрч
ирээд "Чи удахгүй
хүүхэдтэй болох
бөгөөд тэр маш**

**ОНЦГОЙ
НЭГЭН
БОЛНО"
ГЭВ.**




**Тэр эмэгтэй нөхөртөө энэ
гайхамшигтай мэдээг хэлэв.**



**Манао "Өө Эзэн минь Бидэн уруу
дахин ирээч, Бид төрөх хүүхдийн
төлөө юу хийх ёстойг заагаач"**


**ХЭМЭЭН
залбирчээ.**







Тэнгэр элч Манаод
Бурхан энэ хүүхдийг
шүүгчээр сонгосон
бөгөөд тэр Израилийг
удирдах болно
ГЭЭД ...






... ТҮҮНИЙ ҮСЭНД ХЭЗЭЭ Ч
МЭС ХҮРГЭЖ ҮЛ БОЛНО МӨН
ТЭР АРХИ БОЛОН БУЗАР
ХООЛ ХҮНС ИДЭЖ БОЛОХГҮЙ
ГЭЖЭЭ.






**Энэ үед Бурханы ард түмэнд
гарцаагүй тусламж хэрэгтэй байв.**






**Тэд Бурханыг орхисон бөгөөд тэдний
дайсан болох Филлистичүүд
тэднийг дарлан байлаа.**





**Харин тэд Бурханд залбирсан
бөгөөд Бурхан тэднийг сонсжээ.**





**Тэгээд Бурхан энэ хүүг дэлхийн
хамгийн хүчтэй эр болох болно
гээд хүүг тэдэн уруу илгээжээ.**




**Ийнхүү эмэгтэй хүүг
төрүүлж Самсон гэдэг
нэр өгөв. Хүү өсөж**

**Бурхан түүнийг
ерөөжээ. Хүү
өсөж Бурханы
сүнс түүний
сэтгэлийг
хөдөлгөх
болжээ.**



**Самсон агуу
хүчит эр болов.
Нэгэн өдөр тэр
залуу арслантай
тулалдаад
түүнийг алав.**





Нэгэн өдөр түүний
алсан өнөөх арслангийн
сэгэнд зөгий үүрлэн бал байхыг
хараад Самсон балнаас авч идэв.





Тэгээд тэр нэгэн
оньсого зохиожээ.

"Идэгчээс идэх юм гарав.
Хүчтэнээс амттай зүйл гарав."





Онъсогын хариуг
хэн ч олсонгүй харин
Самсоны Филистчүүдаас
авсан эхнэр нь нөхрөөсөө ...






... хариултыг нь
асуугаад найзууддаа
хэлж өгчээ. Самсон
үүнд маш их уурлав.




**Удалгүй Филистчүүд түүний
эхнэрийг найзад нь эхнэр болгон
өгсөнд Самсон ихэд уурлав. Тэр
тэднээс өшөөгөө авахаар төлөвлөжээ.**


**Гэвч
яаж?**




**Эхлээд Самсон гурван зуун үнэг
барив. Тэгээд тэднийг сүүл сүүлээр
нь холбож хоёр сүүлний хооронд
бамбар уяв.**



Самсон тэднийг Филистчүүдийн тариан талбайд оруулав!



Тэдний бүх ургац шатжээ.




Филистчүүд түүнээс өшөөгөө авахыг хүсэж байлаа. Самсон өөрийгөө хүлээд Филистчүүдэд өгөхийг зөвшөөрчээ.




**Гэтэл Бурханы сүнс
Самсон дээр хүчтэй
буув. Тэрээр хүлсэн
олсоо тастаад үхээд
удаагүй илжигний
эрүүний яс олж
мянгаад дайснаа
устгав.**



Филистчүүдийн цэргүүд Самсоныг
хайж байв. Нэгэн шөнө тэд түүнийг
барихаар хотын хаалгыг түгжжээ.



Гэвч Самсон шөнө дөлөөр гарч
хотын хаалгыг булга татан хоёр
мөрөн дээрээ тэгнэн зугтжээ.



**Гэвч Самсон Бурханы өмнө
буруу зүйл хийсэн байлаа.
Бурхан амласныхаа
дагуу түүнд агуу
хүч чадлыг
өгсөн
юм.**



**Нэгэн өдөр Самсон өөрийн хүч
чадлын нууцыг Делила
гэдэг Филистчүүдийн
тагнуул эмэгтэйд
хэлчхэж
гэнэ.**



Тэр түүнд дурласан
байв. Ингээд тэр
эмэгтэй Самсоныг
унтаж байх зуур
түүний үсийг
хусжээ.



**Удалгүй Филистчүүдийн
цэргүүд Делилагын
унтлагын өрөөнд
байсан
Самсонруу
дайрав.**



**Самсон тэдэн
уруу дайрсан
боловч түүний
хүч алга болсон
байв. Дайснууд
түүний нүдийг
сохолжээ.**



**Сохор бас
хүч чадалгүй
дорой болсон
Самсон
Филистчүүдий
н зарц болов.**



**Тэд Бурханы
үйлчлэгчийг
доромжилж
түүгээр тоглоом
хийж инээлддэг
байлаа.**



**Нэгэн өдөр
Филистчүүдийн
найр болж байв.
Тэр өөрсдийн
шүтээндээ
мөргөхөөр том
дуганд цугласан
байв.**




**Тэд ууж идэцгээж
наргиж байлаа.**

**Тэгээд тэд
Самсоныг
өөрсдийгөө
хөгжөөлгөхөөр
дууджээ.**




**Нэгэн хүү Самсоныг хөтлөн ирж
түүнийг дуганы баганыг түшүүлэн**

ЗОГСООВ.




**Тэнд гурван мянга гаруй
Филистчүүд байсан бөгөөд бүгд**


**ТҮҮНИЙГ
хараад
ШООЛОН
ИНЭЭЛДЭЖ
байв.**



**Харин Самсоны үс хусуулснаасаа
хойш шоронд байх зуур ургаж
ЭХЭЛСЭН байв.**



**Тэгээд Самсон ийнхүү залбирав
"Эзэн БУРХАН минь, намайг санан**




**соёрхооч.
Бурхан
минь,
ЗӨВХӨН
ЭНЭ удаа
л надад
хүчийг
ӨГӨӨЧ.**




**Би ганцхан л удаа хоёр нүднийхээ
төлөө филистчүүдээс өшөөгөө авъя''**


ХЭМЭЭВ.



**Бурхан Самсонд хүч
чадлыг дахин өгсөн
болов уу? Самсонд
энэ боломжтой
болов уу? Тийм
ээ! Тийм!**



**Тэр хүч чадал
орж дуганы
хоёр баганыг
хоёр гараараа
ТҮЛХЭВ.**



**Тэр даруй дуган нурж
дотор нь байсан
Самсон болон
мянга гаруй
филистчүүд
бүгд
дарагдан
нас баржээ.**



Бурханы хүчит эр Самсон

Бурханы үг Библиээс авсан түүх

Шүүгчид 13-16

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16

